



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

Ажлын байрны жагсаалт батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг батлах тухай” Монгол улсын Засгийн газрын 2016 оны 08 дугаар тогтоол, “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” нийслэлийн Засаг даргын 2016 оны А/635 дугаар захирамж, газрын дүрмийн 2.5.1, 2.5.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын ажлын байрны жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, зохион байгуулалтын бүтцийн схемийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2018 оны А/16 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

1150500008


Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 01
сарын 15 өдрийн А/02 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5234325 СБТ 8936 1118263502

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСААЛТ

1. Дарга
 2. Орлогч дарга
- Захиргааны хэлтэс**
3. Захиргааны хэлтсийн дарга
 4. Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
 5. Жуулчны аюулгүй байдал, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан ахлах мэргэжилтэн
 6. Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн
 7. Үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн
 8. Архив, бичиг хэргийн эрхлэгч
- Бодлого, төлөвлөлтийн хэлтэс**
9. Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
 10. Хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
 11. Хяналт шинжилгээ, үнэлгээ, статистик, сургалт, судалгаа хариуцсан мэргэжилтэн
 12. Соёлын аялал жуулчлал, эвент арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн
 13. Дотоодын аялал жуулчлал, бүтээгдэхүүний хөгжил хариуцсан мэргэжилтэн
- Мэдээлэл, сурталчилгааны хэлтэс**
14. Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн дарга
 15. Хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
 16. Маркетинг, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
 17. Олон нийтийн харилцаа хариуцсан мэргэжилтэн
 18. Мэдээлэл, сурталчилгааны төв хариуцсан менежер

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2019 оны 01 сарын 16-ны өдрийн А. Дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦИЙН СХЕМ

